
1SECOND 4EVER
ШУВРАЛ-8

# "1 Second 4 Ever" комик цуврал #8
"Гэрэлтэй цонхмс"

Зураач: Б. Тэлмэн
Зохиолч: А. Марал
Зөвлөх: З. Сэцэн, Г. Нямпүрэв

Энэхүү бүтээл нь "TEST4UB" кампанит ажлын хүрээнд бүтээгдэж, зохиогчийн эрхийн хуулиар бүрэн хамгаалагдсан болно. Бүтээлийг бүтнээр болон хэсэгчлэн хувилах, нийтлэх, цахим хэлбэрт оруулах, ямар нэгэн хэлбэрээр олшруулахыг хориглоно. Энэхүү бүтээл нь "Залуус эрүүл мэнд төв" ТББ-ын өмч болно.

2020 он.


#7: "ГЭРЭЛТЭЙ ЦОНХ"


10 ЖИЛ ӨНГӨРЧЭЭ.


ЧИ НАДАД ХАМГИЙН САЙХАН ДУРСАМЖЫГ БЭЛЭГЛЭСЭН.


ТЭР ҮЕД БИ ИХ ТОМ ТОЛГОЙТОЙ ХҮҮ БАЙЖ БИЛЭЭ.


БАС ИХ
ХЭНЭГГҮЙ.


ӨӨХ,
ҮГҮЙ ЭЭ.


ЭНЭ ЯМАР ҮНЭТЭЙ МАШИН ГЭДГИЙГ МЭДЭЖ БАЙНА УУ?
БИД ТӨЛНӨӨ. ТӨЛЧИХВӨЛ Л БОЛОО ЮМ БИШ ҮҮ?
ЭНИЙГ ТӨЛӨӨРЭЙ.
500'000₮


ХОЁУЛАА ОДОО ЯАЖ МӨНГӨ ОЛНО?
САНАА ЗОВОХ ХЭРЭГГҮЙ ДЭЭ. ЯМАР ЧИ ХАГЛАСАН БИШ. БИ ТӨЛНӨӨ.
500'000₮



АСРАГЧИЙН АЖИЛД АВНА.
ЦАЛИН САРЫН 500,000
АСРАГЧИЙН АЖИЛД АВНА.
ЦАЛИН САРЫН 500,000


УУЧЛААРАЙ. ЗАРЫН ДАГУУ ЯВЖ БАЙНА.
ОР Л ДОО.


БИД НЭГ САР ГАДААД ЯВААД ИРЭХ ГЭЖ БАЙГАА ЮМ. ХҮҮГ МААНЬ ТЭР ХУГАЦААНД ХАРАХ ХҮН БАЙХГҮЙ БОЛОХООР БИД ЗАР ТАВЬСАН ЮМ.
БИ ЧАМАЙГ ХАРЖ БАЙСАН ЮМ ШИГ БАЙНА. МАНАЙ СУРГУУЛЬД ЯВДАГ БИЛҮҮ?
АШГҮЙ ХҮҮТЭЙ МИНЬ НЭГ СУРГУУЛЬД ЯВДАГ БОЛ ХАРЖ ХАНДААД БАЙЖ БОЛОХ ЮМ БАЙНА ШҮҮ ДЭЭ.
НАДАД ХАРАХ ХҮН ХЭРЭГГҮЙ ГЭЖ ХЭЛЭЭ БИЗ ДЭЭ. БИ ГАНЦААРАА САР БАЙЖ ЧАДНА.


БИТГИЙ САНАА ЗОВООРОЙ. ХҮҮ МААНЬ ӨӨРИЙН НАСНЫ ХҮҮХЭД ХАРААД САНАА ЗОВЧИХ ШИГ БОЛЛОО.
НАДАД ДААТГАЖ БОЛНО. БИ ХАРЖ ХАНДААД БАЙЖ ЧАДНА.
GOJIRA
CALLING ...
TULGA


БАЙНА УУ?
ТИЙМЭЭ ЗАВТАЙ БАЙНА. ОДОО ЮУ?
ЗА, БИ ЯВААД ОЧЪЁ.
ХАНГАЙ!
ЯВАХ АЖИЛ ГАРЧИХСАН УУ?
ЮУ Л ДАА. БИ НӨГӨӨ...
ЯВ ДАА.
ХЭРЭГ ГАРВАЛ НАД РУУ ЗАЛГААРАЙ... БАС МАРГААШ СУРГУУЛЬ ДЭЭР...
ЗУГЭЭР ДЭЭ ЧАМАЙГ ИЙМ АЖИЛ ХИЙЖ БАЙГААГ ЧИНЬ ХЭЛЭХГҮЙ, ТАНИХГҮЙ ЦАРАЙЛАХАД БОЛНО БИЗ ДЭЭ.
БАЯРЛАЛАА.


ХАНГАЙ!
БИ БУЦААД ИРЛЭЭ.
ЧИ ЯВНА ГЭСЭН ЯАСАН?


БИ ЦАЛИН АВЧ АЖИЛ ХИЙЖ БАЙГАА ХҮН ШҮҮ ДЭЭ.
ХОЁУЛАА ЦУГ СУУЖ ХООЛЛОЁ.
НЭЭРЭЭ...


БИ ГҮЙЖ ҮЗЭХИЙГ ХҮСДЭГ.
ЧИ ГҮЙЖ ЧАДНА ШҮҮ ДЭЭ.
ГЭХДЭЭ БИ...


ӨНӨӨДӨР ҮНЭХЭЭР ГОЁ БАЙЛАА.


МАРГААШ НЬ.


ХӨӨЕ!!!
ТА НАР УУЧЛАЛТ ГУЙХ ЁСТОЙ ЮМ БИШ ҮҮ?
БАС БААТАР ГАРААД ИРЖ.


МИНИЙ ХЭН БАЙХ ХАМААГҮЙ. ЗҮГЭЭР Л ХҮН ШИГ ХАРЬЦ.


ӨНӨӨДӨР ЧИ НАДАД ТУСЛАХ ХЭРЭГ БАЙГААГҮЙ ШҮҮ ДЭЭ.
ТЭДНИЙГ ХАРАХААС ДУРГҮЙ ХҮРЭЭД БАЙСАН ЮМ.
CALLING...
TULGA
БАЙНА УУ?
ААН ОДОО ЮУ?


ЯВ.
БИ ЯВААД ОЧЪЁ.
САЙН УУ? ТАНИЛЦААРАЙ.


САЙХАНАА.
АРИУНАА.
НАДАД ТААЛАГДДАГ ОХИН ГЭЖ БИ ЧАМД ХЭЛЖ БАЙСАН ДАА.
ХӨӨРХӨН ОХИН БАЙНА. БИ ЯВАХ АЖИЛТАЙ БОЛЧИХЛОО.
ЮУ БОЛСОН ЮМ БЭ?


БИ ЧАМАЙГ НАЙЗАА ГЭЖ БОДДОГ УЧИР Л ХЭЛЖ БАЙНА. БИ НЭГ ХҮНД САЙН БАЙСАН ЮМ АА. ГЭТЭЛ ТЭР НАДАД ХАЙРГҮЙ ИНГЭЭД Л БОЛЛОО.
ХҮН ХЭНИЙГ ХАЙРЛАХ НЬ ХАМААГҮЙ ШҮҮ ДЭЭ. ХАРИН ТЭР ХҮНЭЭ ХАЙРЛАДАГ ШИГЭЭ ЯВУУЛЖ ЧАДДАГ БАЙХ НЬ ЧУХАЛ БАЙХ ДАА.
ЧИ ХАЙР ДУРЛАЛЫН ТАЛААР ЮУ МЭДЭХ ЮМ БЭ?
НАМАЙГ ТЭРГЭНЦЭРТЭЙ БОЛОХООР ХАЙРЛАЖ ЧАДАХГҮЙ ГЭЖ БОДСОН ЮМ БИШ БИЗ ДЭЭ?
ҮГҮЙ ЭЭ БИ БУРУУ ЗҮЙЛ АСУУЧИХЛАА. УУЧЛААРАЙ. БИ ЗҮГЭЭР Л ЭВЛЭРЧ ЧАДАХГҮЙ БАЙХ ШИГ БАЙНА.ГЭХДЭЭ ЧИ ХАЖУУД БАЙГАА БОЛОХООР ЯАГААД Ч ЮМ ХҮНД САНАГДАХГҮЙ ЮМ. ИНГЭЖ СЭТГЭЛЭЭ ХУВААЛЦАХ ХҮН НАДАД ЧАМААС ӨӨР АЛГА ДАА.


МАРГААШ ГЭРИЙНХЭН ИРНЭ. ЭНЭ САРЫН ХУГАЦАА ЯМАР ХУРДАН ӨНГӨРЧИХӨВ ӨӨ?
ТИЙМ БАЙНА ШҮҮ. ТЭГВЭЛ ӨНӨӨДӨР МИНИЙ АЖЛЫН СҮҮЛИЙН ӨДӨР БАЙХ НЬ.


ХАНГАЙГ САЙН ХАРЖ
ХАНДАЖ БАЙГААРАЙ.